

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28

№ 25/01

Улаанбаатар хот

ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 (Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 2,127,676 (Хоёр сая нэг зуун хорин долоон мянга зургаан зуун далан зургаа) ширхэг болгох тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж цаашид шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч /Ц.Тайшир/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28

№ 2/02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХООР ШИЙДВЭРЛЭЖ, ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ЭНГИЙН ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 12,407 (Арван хоёр мянга дөрвөн зуун долоон төгрөг) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 (Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо) ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан Авлагын гэрээний холбогдох заалтын дагуу 25,009,993,379 (хорин таван тэрбум есөн сая ерэн гурван мянга гурван зуун далан ес) төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэх тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж цаашид шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч /Ц.Тайшир/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28

№ 25/03

Улаанбаатар хот

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10, 62.1.11 дэх заалт, 2025 оны 01 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- Өндөрхаан ХК-ийн өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах гэж буйтай холбогдуулан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлийн дагуу сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний гэрээ, хэлцэл байгуулах тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж цаашид шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч /Ц.Тайшир/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

“ӨНДӨРХААН” ХК

Өндөрхаан ХК-ийн 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн
25/03... дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
тогтоолын Хавсралт 1



№	Хийгдэх гэрээ	Гэрээний үнэ	Оролцогч тал
1	Хувьцаа худалдах худалдан авах гэрээ	25,009,993,379 (хорин таван тэрбум есөн сая ерэн гурван мянга гурван зуун далан ес) төгрөг	Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Өндөрхаан ХК

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28

№ 25/04

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХТОЙ ХОЛБОГДУУЛАН ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ГАРГАЖ БҮЙ ЭНГИЙН ХУВЬЦААНААС ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, 2025 оны 01 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компаниас нэмж гаргах 2,015,797 (Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо) ширхэг энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлүүлэхгүй байх тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж цаашид шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч /Ц.Тайшир/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

“ӨНДӨРХААН” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28

№ 25/05

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 2025 оны 01 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж цаашид шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгч /Ц.Тайшир/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ